

БАТЛАВ: ЗАХИРАЛ

Д-р Ч.БАТЦЭЦЭГ
2014 оны 10 сарын 09 өдөр

Монгол Улсын Их Сургуулийн "Байгаль-Эх лицей" ахлах сургуулийн
гүнзгийрүүлсэн сургалттай ангид суралцуулах ГЭРЭЭ

2014 оны 09 дугаар сарын 24

№ 254

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Суралцах гэрээг нэг талаас МУИС-ийн "Байгаль-Эх лицей" ахлах сургуулийг төлөөлж сургалтын менежер Төвдөөс овогтой Буяндэлгэр, негее талаас Матшиагийн 118 ангийн Монголдот овогтой Монголдот /цаашид суралцагч гэх/, эцэг /эх/ Монголдот овогтой Монголдот нар харилцан тохиролцож Монгол Улсын Боловсролын багц хууль, "Байгаль-Эх лицей" ахлах сургуулийн дотоод дүрмийг үндэслэн байгуулав.

1.2. Сургууль, суралцагч, эцэг /эх/-ийн харилцааг Боловсролын тухай багц хууль, бусад хууль тогтоомж, "Байгаль-Эх лицей"-д мөрдөгдөж буй дүрэм, энэхүү гэрээгээр зохицуулж тэдгээрт заагдсан үүргийг талууд адил хүлээнэ.

1.3. Гүнзгийрүүлсэн сургалттай ангид элсэх болзол хангасан Монголдот овогтой Монголдот –г "Байгаль-Эх лицей" ахлах сургуулийн Матшиагийн 118 ангид суралцуулахаар элсүүлэв.

1.4. Сургуульд шинээр элсэгч нь суралцах хугацааны хичээлийн жил тутамд гүнзгийрүүлсэн сургалтын нэмэгдэл зардлын төлбөр /Сургуулийн удирдах зөвлөл тогтоосон/ төлнө.

Хоёр. Сургуулийн хүлээх үрэг

2.1. Суралцагч бүрт чанартай, хүртээмжтэй бүрэн дунд боловсрол олгох, хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, хүсэл сонирхол, онцлогт нийцсэн боловсрлын үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн бүхий л нөөц боломж, чадавхийг дайчлан ажиллана.

2.2. Суралцагчиддаа сургалт явуулахад зайлшгүй шаардагдах сургуулийн эзэмшлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, компьютерийн лаборатори, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн шаардлагатай лаборатори, тоног төхөөрөмж, номын сангийн үйлчилгээг үнз төлбөргүй ашиглуулна.

2.3. Суралцагчид бүрэн дунд боловсролын стандартыг бүрэн эзэмшүүлэхийн зэрэгцээ, сонгосон хичээлийг гүнзгийрүүлэн зааж, амжилттай суралцаж төгссөн бол бүрэн дунд боловсролын үнэмлэх олгоно.

2.4. Гэрээг хичээлийн жилийн эцэст дүгнэж, дүнг багш нарын болон сургуулийн эцэг эхийн зөвлөлийн хамтарсан хурлаар хэлэлцэж цаашид сунгах эсэх тухай шийдвэр гаргаж эцэг, эх суралцагчдад танилцуулна.

Гурав. Сургуулийн здлэх эрх

1. Суралцагчаас гэрээгээр хүлээсэн үүргээ ямагт биелүүлэхийг шаардах
2. Холбогдох дүрэм, журамд заасны дагуу суралцах гэрээг цуцлах

Дөрөв. Суралцагчийн хүлээх үүрэг

4.1. Сургалтын хөтөлберийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших, амжилттай /стандарт үнэлгээ 80%-аас доошгүй/ суралцахын төлөө өөрийн бүхий л нөөц боломжоо бүрэн дайчлан ажиллах

4.2. Суралцагчийн ёс зүйн дүрмийг зөрчихгүй байх, сургууль багшаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, сургуулийн дотоод журам, бусад мөрдөгдж буй дүрмийг хүндэтгэн сахина.

4.3. Гүнзгийрүүлсэн сургалтын нэмэгдэл зардлын төлбөрийг зохих хугацаанд бүрэн төлне.

4.4. Сургууль хамт олноос зохион явуулсан уралдаан тэмцээн, олимпиадад идэвхтэй оролцож байх.

4.5. Сургуулийн удирдах ажилтан, анги удирдсан болон хичээл заадаг багш нар, суралцагчдын өөрөө удирдах зөвлөл /СӨҮЗ/, анги хамт олноос өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд чанартай гүйцэтгэж байх.

Тав. Эцэг /эх/-ийн хүлээх үүрэг

5.1. Хүүхдээ "Зөв Монгол Хүн" болон төлөвших, амжилттай сайн суралцаж авьяас чадвараа нээн хөгжүүлэхэд нь гэр бүлийн хүрээний шаардлагатай нөхцөл боломжоор хангах

5.2. Сургууль, багш наортай байнгын холбоо харилцаатай байж хамтран ажиллах

5.3. Улирал тутмын болон явцын төвшин тогтох шалгалтын дун, хүүхдийнхээ мэдлэг чадварын өсөлт, ахиц өөрчлөлтийг анхаарч гурвалсан гэрээний биелэлтэд дэмжлэг өгч байх.

5.4. Ангийн болон сургуулийн эцэг /эх/-ийн зөвлөл, анги удирдсан багш, сургуулиас зохиосон сургалт-төлөвшлийн аливаа ажилд идэвхтэй бүтээлч оролцох, бүх талаар дэмжиж ажиллах.

Зургаа. Гэрээ цуцлах нөхцөл

Дараах тохиолдлуудад энэхүү гэрээг сургуулийн санаачлагаар цуцална. Үүнд:

6.1. Бусдыг хэл амаар доромжлох, нэр хоч өгөх, бүлэглэн дарамтлах, сэтгэл санааны болон бие махбодын хохирол учруулах, хулгай хийх, мөнгө төгрөг нэхэх зэрэг хэв журмын зөрчил гаргасан тохиолдолд.

6.2. Хичээлийн жилийн явцад зохион байгуулсан гүнзгийрүүлэн судалж буй болон бусад хичээлийн мэдлэг, чадвар хөгжлийн түвшин тогтоох шалгалтуудын дундаж гүйцэтгэлээр хангалтгүй "F" түвшинд дүгнэгдсэн.

6.3. Согтууруулах ундаа, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн, элдэв муу зуршилд автах болон хэв журмын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд.

Долоо. Гэрээний хүчинтэй хугацаа, маргаан шийдвэрлэх

7.1. Энэхүү гэрээг 3 талын гарын үсэг зурсан өдрөөс хүчинтэйд тооцно.

7.2. Гэрээг 3 тал нэг хичээлийн жилийн хугацаагаар байгуулна.


7.3. Гэрээний хугацаа дуусахаас өмнө сургууль, суралцагч, эцэг /эх/-ийн аль нь ч гэрээг цуцлах санал тавиагүй бол уг гэрээг өмнөх хугацаагаар сунгагдсанд тооцно.

7.4. Гэрээний 6.1, 6.3 дах нөхцлөөр гэрээ цуцлагдсан тохиолдолд сургалтын төлбөрийн үлдэгдлийг буцааж олгохгүй, харин суралцагчийн санаачлагаар гэрээ цуцлагдвал сургалтын үлдэгдэл төлбөрийн 10% нь сургуульд үлдэнэ.

7.5 Гэрээ цуцлах асуудлаар маргаан үүсвэл аль ч тал боловсролын мэргэжлийн хяналтын байгууллагад хандах эрхтэй.

Гэрээ байгуулсан:


"Байгаль-Эх лицей" ахлах
сургуулийн сургалтын менежер



Т. Буяндэлгэр

Утас: 88001664

Математик 1/9
ангийн сурагч



М. Чумукхут

Утас: 95560089

Эцэг /эх/



Н. Маматгүл

Утас: 95581899

99301595